



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/21.

Чингис хот

Г.Намсрайжавд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам"-ын 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ахмад настан Г.Намсрайжавын ирүүлсэн өргөдлийн дагуу Сангийн зөвлөл хуралдаж санал ирүүлснийг үндэслэн эмчилгээний зардалд шаардагдах 200.000 /хоёр зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг байгууллагын ахмадын сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030124